

# Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна

Есүс  
бол  
агуу  
багш



**Зохиогч: Edward Hughes**

**Зураглаач: Byron Unger; Lazarus**

**Найруулсан: E. Frischbutter; Sarah S.**

**Орчуулсан: Damdin Norolsuren**

**Alastair Paterson**

**Бүтээсэн: Bible for Children**

**[www.M1914.org](http://www.M1914.org)**

**©2020 Bible for Children, Inc.**

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах  
эрхтэй харин худалдахыг хориглоно.**





**Есүс бол  
үргэлж агуу багш  
байсан юм. Ард олон  
түүнийг сонсож байв.**





**Есүс тэдэнд  
нигүүлсэнгүй сайхан  
сэтгэлтэй байх ёстой  
гэж сургаж байлаа.**





**Бусад  
хүмүүс тэднийг үзэн  
ядаж бас зовоож байсан ч  
Бурхан тэднийг ийнхүү  
хайрласан юм.**



**Есүс  
ТЭДЭНД  
ОЛОН  
ЗҮЙЛИЙГ  
заасан.**





**Тэр  
дэнгийн  
гэрэл  
байшинг  
гэрэлтүүлдэг  
шиг Бурханы  
хүмүүс  
дэлхий ...**





... ертөнцийг  
гэрэлтүүлэх  
ёстой гэж  
зааж байв.  
Дэнгийн  
гэрэл  
харанхуй  
өрөөг ямар  
болгодог  
билээ дээ!






**Хүмүүс "нүдийг нүдээр,  
шүдийг шүдээр" гэж**


**ӨС ХОНЗОН**

**АВАХЫГ**

**ЯРЬДАГ.**



**Харин Есүс дайснаа  
уучлах, нинжин  
сэтгэлээр  
хандаж  
тэднийг  
хайрлахыг  
зааж  
байлаа.**



**Есүсийг харж байхад,  
зарим хүмүүс ариун  
байдлын дүр эсгэж  
байлаа.**



**Тэд гуйлгачинд  
мөнгө өгөөд хүмүүст  
харуулахын тулд  
хүмүүсийн өмнө  
бүрээ татаж  
байв.**



**"Өглөг чинь нууц  
байвал Бурхан та  
нарыг шагнах болно"  
гэж Есүс хэлэв.**



**Есүс мөргөгчдын  
талаар үүнтэй  
адил хэлсэн юм.**



**Зарим хүмүүс гудамжинд зогсоод  
залбирдаг бөгөөд бусад хүмүүс**

**түүнийг харж бас  
сонсоно гэж тэд  
боддог.**



**Тэд Бурханы талаар мэдэхгүй ажээ.  
Тэдэнд зөвхөн бусад хүмүүсийн бодол  
чухал ажээ. Есүс тэднийг хоёр нүүрт  
хуурамч жүжигчид  
ХЭМЭЭН дууджээ.**





**Есүс сургаал заахдаа байгаль  
дээр оршин байгаа зүйлээр  
тайлбарладаг байв.**



Жишээ нь, Тэр шувууг  
заагаад, "Тэнгэрлэг  
Эцэг тань тэднийг  
тэжээдэг," ...



... гээд "Бүү санаа зов.  
Бурхан бас та нарыг  
хангах болно" гэж Тэр  
ХЭЛЭВ.



"Тэр ч байтугай баян тансаг амьдарч  
байсан Соломон хаан ч сараана цэцэг  
шиг хувцаслаж байгаагүй юм,"  
хэмээн Есүс үргэлжлүүлэв.



"Бурхан хээрийн өвсийг ийнхүү  
гоёдог бол, Тэр бас та нарыг  
хувцаслах биш үү?"



Есүс биднийг бүх зүйлээр хангагч  
Бурханд итгэг тун хэмээн сургаж  
байлаа.



"Хэрэв та өөрийн ах дүүгээ шүүдэг  
бол өөрийн чинь  
нүдэнд дүнз  
байх атал  
ах дүүстээ  
"Нүднээс  
чинь тэр  
үрэтсийг  
аваад өгье" гэж  
хэлнэ гэж үү?



**ЭХЛЭЭД НҮДНЭЭСЭЭ  
ДҮНЗЭЭ авч хая,  
ТЭГВЭЛ ЧИ АХ  
ДҮҮГИЙНХЭЭ  
НҮДНЭЭС  
ҮРЭТСИЙГ  
авч хаяхдаа  
сайн харах  
болно.**





**гэж Есүс хэлэв. Үүнийг сонсоод  
хүмүүс инээд  
алдсан байх.  
Харин тэд  
үүний  
учир юу  
болохыг  
бодох  
хэрэгтэй  
байв.**



**Есүс хүмүүст хандан  
Бурханд тусламж гуйн  
залбир гэв. Та нарын Эцэг  
хүүхдээ талх  
гуйхад нь  
чулуу  
өгөхгүй  
биз дээ?**



**Үгүй! Тэд сайныг өгнө.  
Бурхан ч бас өөрөөс нь  
гуйдаг хүнд сайныг өгөх нь  
гарцаагүй юм.**



**Есүс бас хуурамч багш нараас  
болгоомжлогтун гэв. "Тэд  
гаднаасаа хонь шиг байв  
ч дотор нь чоно юм"  
гэж Есүс хэлэв.**




**Есүс хэлэхдээ хуурамч багш нарыг  
ТЭДНИЙ амьдралын үр  
ЖИМСНЭЭС харж  
БОЛНО ГЭСЭН ЮМ.**




Тэрээр сургаалт зүйрлэлээр Бурханы  
үгийг дагадаг  
хүмүүс хадан дээр  
байшингаа  
барьсан ...



... мэргэн хүнтэй адил юм.  
Хүчтэй шуурга  
болов. Байшин  
баттай байж  
нурсангүй.




**Харин мунхаг хүн элсэн дээр  
байшингаа барьдаг. Бороо орж үер  
буухад байшин нурав яагаад гэвэл  
суурь нь муу байсан юм.**





**Бурханы үгийн дагуу байдаггүй хэн  
боловч ийм байх болно гэв.**



**Цугласан олон Есүсийн  
үгийг сонсоод ихэд гайхаж  
байлаа. Тэд урьд өмнө  
ийм сургаал сонсож  
байсангүй.**



**Одоо тэд Бурханы үгийг  
сонсоод зогсохгүй өдөр  
бүр түүний үгийг дагаж  
амьдрах ёстой гэдгийг  
ухаарчээ.**



Есүс бол агуу багш

Бурханы үг Библээс авсан түүх

Матай 5-7, Лук 6

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



**Төгсөв**



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



Хэрвээ та энэ үнэнд итгэж  
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:  
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон  
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та  
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж  
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос  
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр  
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд  
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө  
амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай  
ярилцаарай! Иохан 3:16

